

Монгол Улсын хүн амын төрөлт

Д.Нарантуяа

**Хүн Судлалын Үндэсний Төвийн
эрдэм шинжилгээний ажилтан**

Оршил

Монголын хүн ам зүй нь малчид болон нүүдэлчин ахуйгаас суурьшмал амьдралд шилжсэн ард түмний эдийн засаг, улс төр, түүх, сэтгэл зүйн өөрчлөлтийг тусгасан өөрийн онцлог зүй тогтолтой юм.

Олон үеийн турш нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн монгол малчдын хүн ам зүйн чанарын ба тоон үзүүлэлтүүд анагаах ухаан, эрүүл мэндийн салбар болон нийгэм эдийн засгийн хөгжил, тухайн үеийн гадаад дотоод улс төрийн тогтолцооноос шалтгаалан өөрчлөгдөж ирсний дээр улам бүр хүрээгээ тэлэх ажилчин, сэхээтний үзүүлэлтүүдээр баяжсан билээ. Ялангуяа тус улсад явагдсан аж үйлдвэржүүлэлт, нэгдэлжих хөдөлгөөн, лам нарын талаар явуулсан бодлого, түүх судлаачдын дунд янз бүрээр нэрлэгдэх хувьсгал, хөдөлгөөнүүд нь монголын хүн ам зүйд тодорхой нөлөө үзүүлж байсан юм.

Монголын хүн амын тухай мэдээлэл, аргачлал

Монголын хүн амын төрөлтийн түүхэн онцлог, түүний хандлагыг тодорхойлох зорилгоор түүхийн материалууд, тус оронд аялж, судалж шинжилгээ хийж байсан гадаадынханы болон эмнэлгийн экспедицэд оролцсон орос, зөвлөлтийн эмч нарын бичиж үлдээсэн ном, тэмдэглэлүүд, монголын хүн амын тооллого, иргэний бүртгэл мэдээллийн төвийн архивын материал болон өөрийн орны эрдэмтэн судлаачдын бүтээл, эмнэлгийн статистик болон УСГ-ын эмхтгэл зэргийг ашигласан болно.

Иргэний бүртгэл мэдээллийн төвийн компьютерээс авсан 1987 оноос хойшхи төрөлт нас баралтын бүртгэлийн үнэн зөв байдал чанараараа ямарч судалгааны шаардлагыг хангах хэмжээнд хүрэхгүй байсныг энд дурдах нь зүйтэй болов уу.

Энэ зууны эхэн үеийн Монголын хүн амын төрөлт

Хэдийгээр барагцаалсан шинжтэй боловч энэ үеийн хүн амын тоог тодорхойлох гол баримт нь 1918 онд явагдсан монголын хүн ам, малын анхны тооллогын үр дүн юм. Энэ тооллогоор монголын хүн амын 647500 байснаас 5000 нь орос, 100000 орчим нь хятад гэж бүртгэгдсэн байна. (4,7). Энэ үеийн төрөлт бага, нас баралт өндөр, ялангуяа шинэ төрсөн хүүхдийн тал нь ой хүрэлгүй эндэж байсан, халдварт өвчний тархалт их зэрэг шалтгаанаар Монголын хүн амын өсөлт зогсож, буурах хандлагатай байжээ.

Монголын хүн амын өсөлтөд төрөлтийн түвшин нөлөөлсөн нь дамжиггүй. Хэрэв тэр үеийн аялагч жуулчдын бичсэнчлэн Монголын хүн ам мөхлийнхөө ирмэгт тулаад байсан бол нэг өрхөд дунджаар хоёр хүрэхтэй үгүй хүүхэд насанд хүрдэг байжээ гэж дүгнэж болно. Харин

төрөлт ямар шалтгааны улмаас бага байсныг эрдэмтэд олон янзаар тайлбарлахыг оролдсон байдаг.

Юуны өмнө төрөлтийн бага түвшинг тэр үеийн хүн амын дунд бэлгийн замаар халдварлах өвчний тархалт их байсантай холбон үзэх нь зүйтэй юм. Улаанбаатар, Өндөрхаанд явуулсан зөвлөлтийн эмч нарын эмнэлэг-эрүүл ахуйн 2-р экспедицийн тайлангаас (1) үзэхэд үзлэгт хамрагдсан 484 эхчүүдийн 160 буюу 36 хувь нь тэмбүү, заг хүйтэн өвчтэй, 67 буюу 13 хувь нь эмэгтэйчүүдийн ямар нэг өвчтэй байсан байна. Нэг эмэгтэйд дунджаар дөнгөж хоёрхон төрөлт ногдож байсныг дээрх өвчнүүд эмэгтэйчүүдийн төрөлтөд нөлөөлж байсантай холбон тайлбарласан байдаг. Нийт 153 эмэгтэй үргүй байсны 19 хувь нь заг хүйтнээс шалтгаалсан байна. Заг хүйтнээр өвчилсөн эхчүүд голдуу 2-догч үргүйдэлтэй байдаг бол зулбалт, амьгүй болон дутуу төрөлтийн гол шалтгаан нь тэмбүү болдог байжээ. Тус тайлангын материалаас үзэхэд нийт төрөлтийн зөвхөн 70 орчим хувь нь амьд төрөлтөөр төгсч байв. Тус орноор аялж, жуулчилж байсан хүмүүс ч Монголд бэлгийн замаар халдварлах өвчин их тархсан байдгийг тэмдэглэсэн байдаг.

XX зууны эхэн үеийн Монголын төрөлтийн хүн амын төрөлтийн бага түвшинг монголд тэр үед хүчтэй байсан шарын шашинтай мөн холбон тайлбарладаг. Тэр үеийн насанд хүрсэн эрэгтэйчүүдийн 40-өөд хувь нь сүм хийдэд шавилан сууж эхнэр авдаггүй байсан нь тус улсын хүн амын төрөлтөд сөргөөр нөлөөлсөн гэж үздэг. Гэвч шашнаас улбаалсан гэрлэх боломжтой насны хүн амын хүйсний харьцааны алдагдлыг олон эрэгтэйтэй хамтран амьдрах хэлбэрээр нөхөж байсан гэж судлаач үзэж байгаа юм. Зөвлөлтийн эмч нарын тайлангаас үзсэн ч асуулга авсан 200 эмэгтэйн зөвхөн 2 нь л нэг эрэгтэйтэй, бусад нь олон эрэгтэйтэй хамтран амьдардаг гэж хариулсан байдаг юм (1).

Түүнээс гадна шашны дэг жаяг хатуу байсан ч бэлгийн амьдралд орсон ламын тоо цөөн бус байсан гэж судлаач таамаглаж байгаа боловч уран зохиолын номыг эс тооцвол түүхийн бодит сурвалжуудад энэ тухай эх дурьдсан нь тухайн үед лам нарын нэр хүнд өндөр, ёс бус зүйл нь нууцлаг байсантай холбоотой болов уу гэж бодож байна.

Полигам буюу олон эрэгтэйтэй амьдрах хэлбэр эрэгтэй хүн дутмаг говийн аймгуудад одоог хүртэл ажиглагдсаар байгаа бөгөөд " байдаг хүн", " байдаг айл" гэсэн томъёолол хүн амын зохистой бодлогыг нийгэм эдийн засгийн бодлоготой зөв уялдуулан явуулаагүй үед оршсоор л байх буй заа.

Төрөлтийн завсрын хүчин зүйлс болох хүүхэд хөхүүлэлт, эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх чадвартай байх хугацаа, төрөлт зохицуулах ямар нэг оролдлого хийж байсан эсэх нь тэр үеийн төрөлтийн бага түвшинд хэрхэн нөлөөлж байсныг авч үзэе.

Тэр үеийн эмэгтэйчүүдийн дийлэнх нь сарын тэмдгээ үзэгдэхээс өмнө бэлгийн харьцаанд орж байсан бөгөөд тэдний хүүхэд төрүүлэх чадвартай байх хугацаа нь харьцангуй урт, 15-45 насанд буюу 25-30 жил орчим үргэлжилж байсан байна (1).

Хүүхдээ хөхөөр удаан хооллох нь төрсний дараах түр цэвэршилт үргэлжлэх хугацааг уртасгаж, улмаар төрөлт хоорондын зайг ихэсгэдэг. Монгол эхчүүд хүүхдээ 2 нас хүртэл заримдаа 5-6 нас хүртэл нь хөхүүлдэг. Гэвч эх нь сүүтэй ч хүүхдээ 5-6 сартайгаас нь, заримдаа түүнээс ч эрт үнээ ямааны сүүгээр угжих, мах сүүл хөхүүлэх, бор хоолонд дасгах нь олонтаа байв. Хэдийгээр монголчууд хүүхдээ хөхөөр нь хүссэн цагт нь тэжээж, 2 ой буюу түүнээс ч удаан хугацаагаар хөхүүлдэг байсан ч тэр үеийн нялхсын эндэгдлийн үзүүлэлтийг тооцох юм бол хүүхэд хөхүүлэлт нь төрөлт хоорондын зайд нөлөөлөх магадлал нь 50 хувиас бага байгаа юм.

Монголын хүн ам бусад орныхны нэгэн адил жирэмслэлтээс хамгаалах ардын уламжлалт аргуудтай байсан хэдий ч төрөлт нь өргөн тархсан халдварт өвчин, өндөр нас баралтаар аяндаа зохицуулагддаг байснаас түүнийг өргөн хэрэглэх хэрэгцээ бараг үгүй байсан байна. Монголчуудын дунд хүүхэд эрхэмлэх ёсон өндөр, хурга тугал хариулах, мал ахуй эрхлэх буюу хөдөлмөрлөх хүн хүчний шаардлагаас болон хөгшин настай болсон хойноо хөлөө хучуулах, үр удмаа залгуулах хүсэлтэй зэргээс хүүхдийн хэрэгцээ өндөр байсан юм.

Эмэгтэйчүүдийн хүүхэд төрүүлэх чадвартай байх хугацаа урт, төрөлт зохицуулах арга төдийлөн хэрэглэдэггүй, хүүхдийн хэрэгцээ их байх үед зүй ёсоороо байгалийн төрөлт явагдаж байх ёстой атал нэг эмэгтэй дунджаар 2 хүүхэдтэй байсан нь хүн амын дунд халдварт өвчний тархалт их, нялхсын эндэгдэл өндөр байснаас голчлон шалтгаалжээ гэж дүгнэж болох юм.


Ийнхүү цөөн хэдэн ард нь өсөх магадлал багатай байсан хэдий ч Монголын төр засаг үндэс угсаагаа цэвэр авч үлдэх гэсэн бодлогыг эртнээс нааш эрхэмлэж ирсэн билээ. Үүний нэг жишээ нь Монголын автономит засгийг устгасны дараа Хятад цэргийн эрхтэн Сюй Шү Жаны зарласан хэдэн зүйлийн амлалтын хариуд Монголын талаас гаргасан зарим саналууд хэмээх албан бичгүүд болой. Түүнээс сийрүүлбэл, "Их Зунтунгаас" ухуулсан хүн амыг нэмэгдүүлэх зүйл нь маш сайн хэрэг болой, гагцхүү манай Монголчууд гурван товчоо дагаж холбож богтлон үр хөвгүүн олон цөөхөн адилгүй төрөх ба огт үл төрөх нь цөм өөр өөрийн хувь зохиол болохын дээр аливаа хүмүүс угсаа төрлөө мөхөх балрахад дургүй нь нийтийн ёс, ер санааны дураар албадан олон болгохыг хүсэвч тэнгэрийн хугацаа тооноос хэтрэхгүй болов уу. Бас ч манай халхчууд болбоос Богдод итгэж шашинд итгэж үндэс хэлхээ болох тул одоо лам хүнд эм холбоовоос шашны хууль ёсноо ихэд харшлалтай нь явуулбаас үл болох бөгөөд өөрөөр олон болгох арга хайлгүй өвгөдийн хуучин суртал занг дагаж явуулахыг хүсмой" гэсэн байдаг юм (2).

1921-1950


1921 оноос 1950 он хүртэл Монголын хүн амын амьдралд эдийн засаг, анагаах ухаан, улс орны гадаад дотоодын байдал зэргээс шалтгаалж ихээхэн өөрчлөлт гарсан билээ.

1922-1950 онд манай улсын хүн ам 649.9 мянгаас 758.9 мянга болж 109 мянгаар буюу дөнгөж 16.8 хувиар өссөн байна. Энэ үед монголын хүн амын жилийн ундаж өсөлт 0.6 хувь байв (зураг 1).

Зураг 1: Монголын хүн амын өсөлтийн жилийн дундаж хурд
1918-1994



Зураг 2: Насны бүлэг дэх төрөлтийн коэффициент
Онуудаар



1940-өөд оны сүүл хүртэл эрүүл мэнд, боловсролын систем төдийлөн хүчтэй хөгжиж чадаагүй байлаа. 1920-оод оны сүүлээр Улаанбаатар хотын эмнэлгийн дэргэд анхны төрөх тасаг байгуулагдаж, 1947 онд арьс өнгөний эмнэлэг нээгдэв.

1950 он хүртэл монголын хүн амын өсөлт удаан байсны нэг шалтгаан нь төрөлтийн түвшин нас баралтаас төдийлөн их байгаагүйтэй холбоотой. Энэ нь мөн л хүн амын дунд өвчлөл их байсантай холбоотой. Үүнээс гадна 1930-аад оны эхээр хамтрал, коммун хавтгайруулан байгуулснаас хот руу шилжих хөдөлгөөн ихэссэн, лам нарыг цэргээс болон албан татвараас чөлөөлснөөр хүрээ хийдийн лам нарын тоо 50 хувиар өссөн, гадаадад шилжих хөдөлгөөн их байсан, дотоод улс төрийн байдал тогтвортой бус, хүмүүсийг олноор нь хэлмэгдүүлж байсан зэргээс шалтгаалан монголын хүн амын төрөлт төдийлөн нэмэгдсэнгүй. Ялангуяа

Японы түрэмгийллийн аюул ойртсон тэр үед улс орны дотор хардах сэрдэх аюул нөмөрснөөс олон мянган хүн гол төлөв эрэгтэйчүүд хэлмэгдэж нөгөө талаар тухайн үеийн насанд хүрсэн эрэгтэйчүүдийн гуравны нэг нь 3-5 жилийн хугацаагаар цэрэгт алба хаах болсон нь монголын хүн амын төрөлт, өсөлтөнд сөргөөр нөлөөлсөн байна (6).

1950-1970

Дэлхийн анагаах ухааны ололт нэвтэрч, антибиотик дэлгэрч, гадаад дотоодын байдал харьцангуй тогтворжиж ирсэн 1950 иад оноос хүн амын өсөлт нэмэгдэж, насны бүтэц өөрчлөлт гарч эхэлсэн байна. Хүн амын төрөлт ихэсч, нас баралт, ялангуяа бага насны хүүхдийн эндэгдэл буурч ирсэн нь өсөлтийн гол шалтгаан болсон байна.

Ялангуяа тус улсын эрүүл мэндийн салбарын хөгжил хүн амын нас баралтын бууралт, төрөлтийн өсөлтөд таатай нөлөө үзүүлсэн байна. 1960 аад оны эхэн үеийг эцэстэй нь харьцуулахад 10 мянган хүнд ногдох эмчийн тоо 9,7 оос 17,9 эмнэлгийн орны тоо 68-аас 122 болж нэмэгджээ. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмнэлэгт төрөх жирэмсэн эхчүүдийн тоо өссөн зэрэг нь төрөлт өсөхөд нөлөөлсөн бөгөөд 1951 онд 13,9 байсан төрөлтийн ерөнхий коэффициент 1960 онд хамгийн өндөр түвшиндээ буюу 43.2 промильд хүрсэн байлаа.

Энэ хугацаанд хүн амын боловсролын түвшинд мэдэгдэхүйц ахиц гарсныг тэмдэглэх хэрэгтэй юм. 1946 оноос албан хэргийг кирилл бичгээр хөтөлж эхлэхэд хүн амын 18 хувь нь бичигтэй байсан бол 1963 онд нийт хүн амын 72,6, эмэгтэйчүүдийн 64,8 хувь, 1969 онд нийт хүн амын 82,1 хувь, эмэгтэйчүүдийн 75,3 хувь нь бичиг үсэг мэддэг болсон байна. Хүн амын боловсролын чанарын үзүүлэлт ч мөн энэ хугацаанд ахисан байна. Гэвч боловсролын түвшин нэмэгдэхийн хирээр төрөлт буурах хандлага ихэнх хөгжиж буй орнуудад ажиглагддаг бол Монголын хувьд төрөлт, боловсрол аль аль нь зэрэг өсч байсан онцлогтой юм.

Энэ хугацаанд тус орны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилтын үүднээс хөдөлмөрлөх хүчин ихээхэн шаардлагтай гэж үзэж байснаас хүн амыг өсгөх пронаталист бодлого хэрэгжиж байсан бөгөөд үр хөндөх, жирэмслэлтээс хамгаалах ямар нэг арга хэрэгсэл хаалттай байсан үе юм. Хэдийгээр засгийн бодлого хатуу байсан ч хүн ам төрөлтөө зохицуулах арга хэрэгсэл хэрэглэж эхэлсэн байна.


1970-1990

Хүн амын төрөлт 1970 оны дундаас эхлэн буурч эхэлсэн юм. 1980-аад оны үед 30-аад наснаас дээш эмэгтэйчүүд жиэрмслэлтээс хамгаалах хэрэгсэл нэлээд хэрэглэх болсон байна. (зураг 2).

Хотжилт, аж үйлдвэржүүлэлт ч төрөлтийн бууралтад нөлөө үзүүлсэн нь дамжиггүй. Нүүдлийн мал аж ахуй эрхэлж байсан монголчуудын хүүхдээ төрүүлж, өсгөх, аж ахуйгаа эрхлэх үйл явц нэгэн буурин дээр явагддаг байсан бол хотжилт, аж үйлдвэржүүлэлтийг даган энэ хоёр үйл явц салсан нь төрөлтийн бууралтад нөлөөлсөн гэж үзэх үндэслэлтэй. Зөвхөн төвлөрсөн том хот суурингийн төдийгүй хөдөөгийн

ард түмний өсөн нэмэгдэж байгаа боловсролын хэрэгцээ ч, хүн ардын аж амьдралын түвшний дээшлэлт ч хүүхэдтэй болох хэрэгцээг бусад хэрэгцээнээс илүүд үзэхүүд хүргэсэн байна.

Монголын хүн амын төрөлтийн нийлбэр коэффициент буюу нэг эмэгтэй амьдралынхаа турш төрүүлэх хүүхдийн дундаж тоо 1969–1974 онд 7.53 байсан бол 1990 онд 4.45 болж буурсан байна. 3 хотын төрөлтийн нийлбэр коэффициент ихэнх аймгуудад 7 байсан 1970–аад оны үед ч бага байсан бөгөөд аймгуудын хувьд төрөлтийн бууралт нь харилцан адилгүй байна. Өндөр төрөлт баруун болон төвийн аймгуудад илүү ажиглагдаж байгаа бөгөөд төрөлтийн нийлбэр коэффициент 1990 онд эдгээрээс бусад аймгуудад 5.0–аас бага байсан юм (зураг 3).



Төрөлтийн энэ бууралтад төрөлтийн завсрын хүчин зүйлс хэрхэн нөлөөлж болохыг авч үзэе. 1979–1989 онд нийт эмэгтэйчүүдийн дунд хүүхэд төрүүлэх чадвартай насны эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 21.1–23.1 хувь болж өссөн байна. Энэ хугацаанд энэ насны эмэгтэйчүүдийн тооны өсөлтийн хурд 3,8 хувь байсан бол нийт хүн амынх 2.8 хувь байв. Өөрөөр хэлбэл төрөлтийн бууралтад энэ насны эмэгтэйчүүдийн тооны өөрчлөлт нөлөөлөөгүй байна. Энэ хугацаанд гэрлэсэн эмэгтэйчүүдийн хувь 63,4–61,3 болж буурсан бөгөөд гэрлэх дундаж нас 21.6–22.6 болж өссөн байлаа. Гэрлэх нас хойшлох нь төрөлтийн бууралтад нөлөөлдөг боловч энэ үзүүлэлтүүдийн зөрүү нь төдийлөн их биш учир их нөлөө үзүүлээгүй гэж бодож байна. Харин жирэмслэлтээс хамгаалах арга, хэрэгслийн тэр үеийн хэрэглээг судлах ёстой боловч энэ үед хориотойн улмаас албан мэдээ гэж гардаггүй байжээ. Харин 1990 онд Эрүүл мэндийн яам албан ёсоор тараасан хамгаалах

хэрэгслийн мэдээн дээрээ түшиглэн төрөх насны эмэгтэйчүүдийн 11 орчим хувь нь орчин үеийн хамгаалах хэрэгсэл хэрэглэдэг гэсэн бий.

1989 оны эцэс хүртэл үр хөндөлт хаалттай байсан учир албан ёсоор буюу заалтаар үр хөндүүлсэн эхийн тоо төрөлтийн түвшинд төдийлөн нөлөөлөхөөр байсангүй. Гэвч эмнэлгийн статистикийн мэдээгээр "зулбалт ба бусад" гэсэн үзүүлэлт 1000 төрөлт тутамд 168,6, 1989 онд 179,9 байснаа үр хөндөлтийг чөлөөлсний дараах 1990 онд 95,3 буюу бараг 2 дахин буурсан нь зулбалт нэрийн доор эмэгтэйчүүдэд үр хөндөлтөөр төрөлтөө зохицуулж байсныг гэрчилж байгаа юм.

1990 оноос хойшхи монголын хүн амын төрөлт

1990 оны их эргэлтээр эхэлсэн ардчилсан хувьсгалаас хойш улс орны эдийн засаг, нийгэм улс төрийн хийгээд оюун соёлын амьдралд ихээхэн өөрчлөлт гарсан билээ. "Урьд нь социализмд, одоо хэрэг дээрээ капитализмд шилжиж байгаа" (2) Монгол улсын эдийн засаг шилжилтийнхээ анхны жилүүдэд эдийн засгийн гүнзгий хямралтай тулгарсан билээ. Үүний илрэл болох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн уналт, өндөр хурдацтай инфляци, үнийн өсөлт улам нэмэгдэж байгаа ажилгүйдэл, ядуурал, гадаад худалдааны төлбөрийн балансын зөрүү, өр төлөөс нь 1989 оны үр хөндөлтийг чөлөөтэй болгосон явдалтай хавсран монголын хүн амын төрөлтийг эрс бууруулсан юм.

1970-аад оны дундаас эхэлсэн төрөлтийн бууралт нь голдуу ахимаг насны эмэгтэйчүүдийг хамарч байсан бол 1990-ээд оны бууралт нь бүх насны эмэгтэйчүүдийг хамарсан байлаа. Ялангуяа хамгийн их үзүүлэлттэй байдаг 20-29 насны эмэгтэйчүүдийн төрөлт харьцангуй их буурсан байна (зураг 2).


1974-1979 оны дунджаар 7.24, 1979-84 онд 6.34, 1984-1989 онд 5.40 байсан төрөлтийн нийлбэр коэффициент 1993 онд 2.53 болж буурчээ. 1991 он гэхэд ТНК хотуудыг эс оролцуулбал зөвхөн 2 аймагт 3 гаруй, бусад нь түүнээс дээш байсан бол 1993 онд баруун 5 аймаг, Өвөрхангай бусад аймгуудын ТНК 3-аас доош болсон байлаа..

Төрөлтөд нөлөөлөх завсрын хүчин зүйлүүдийг авч үзвэл гэрлэлт 15.3%, хөхөөр тэжээлт 12.8%, үр хөндөлт 39.3 %, жирэмслэлтээс урьдчилан сэргийлэх хамгааллын хэрэглээ 21.6%, бусад хүчин зүйлсийн нөлөө 36.5% байсан байна (3). Эндээс үзвэл төрөлтийн бууралтад үр хөндөлт хамгийн их нөлөө үзүүлсэн нь тодорхой байгаа бөгөөд үр хөндөлтийг чөлөөлсний дараах буюу 1990 онд 1000 төрөлт тутамд ногдох абортын тоо 386.2 байсан юм.

Гэрлэх дундаж нас 1994 онд 1989 оныхоос 0.4 насаар хойшилж 23.3 нас болсон байв. Төрсөн эхчүүдийн 65 хувь нь хүүхдээ ой хүртэл нь хөхөөр нь тэжээдэг байв. Хөхөөр тэжээдэг дундаж хугацаа монголд 15.5 сар байгаа бөгөөд төрөлтийн дараа түр цэвэршилт явагдах хугацаа 6.2 сар байгаа юм (3).

МУИС-ийн хүн ам зүйн сургалт судалгааны төвөөс хийсэн судалгаанаас үзэхэд төрөх насны эмэгтэйчүүдийн 61 хувь нь жирэмслэлтээс сэргийлэх ямар нэг арга хэрэглэдэг байна. Эмэгтэйчүүдийн 25 орчим хувь

нь орчин үеийн аргуудыг, ялангуяа ерөндөг 19.4 %, бэлгэвч 3,5% хэрэглэдэг юм байна (3).



Энэ бүхнээс дүгнэхэд үр хөндөлт, жирэмслэлтээс хамгаалах хэрэгслийн хэрэглээний өсөлт нь улс орны эдийн засгийн хямралтай хавсран энэ үеийн төрөлтийн бууралтад нөлөөлжээ гэх үндэстэй байна.

Дүгнэлт

Энэ зууны эхэнд "мөхөх" гэж байсан Монголын хүн ам эдүгээ 2 сая гаруйгаар тоологдох болсон нь тус улсын хүн ам зүйд гарсан том өөрчлөлт билээ. Монголын хүн амын өсөлт нь хүн амын нас баралтын бууралт, төрөлтийн өсөлтөөр голлон тодорхойлогдож байгаа бөгөөд дотоод гадаад шилжих хөдөлгөөн онцгой нөлөөлсөнгүй. Монголчууд эртнээс нааш хүүхдийг эрхэмлэж ирсэн бөгөөд үр удмаа үлдээж, үндэс угсаагаа залгуулах, хөлөө хучуулж, хурга тугалдаа гүйлгэх, хүүхэд олонтой байх тусмаа "баян" гэгдэж байсан боловч энэ зууны эхний хагас хүртэл нэг өрх дунджаар хоёрхон хүүхэдтэй байсан нь тус орны хүн амын дунд халдварт өвчин ялангуяа бэлгийн замаар халдварлах өвчний тархалт их, эмнэлэг үйлчилгээ муу, нялхсын эндэгдэл өндөр байснаас голлон шатгаалж байжээ.

1950-иад оноос анагаах ухааны ололт нэвтэрч, хүн амын амьдрал дээшилж ирснээр нас баралтын түвшин эрс буурсан нь төрсөн хүүхдийн амьдрах магадлалыг нэмэгдүүлсэн байна. Төрсөн хүүхдийн амьдрах магадлал ихэссэн буюу 1970-аад оны эх гэхэд эмэгтэйчүүд ямар нэг хэмжээгээр хамгаалах хэрэгсэл хэрэглэж эхлэх болсон байна. Хэдийгээр засгаас олон хүүхэдтэй эхчүүдийг урамшуулан, тэтгэж эхийн одонгоор хүртэл шагнаж байсан, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэл хэрэглэх үр

хөндүүлэхийг хориглож байсан боловч 1970-иад оны дундаас буурч эхэлсэн төрөлт 1980-аад оны үед улам багассаар 1990-ээд он буюу үр хөндөлтийг чөлөөтэй болгосон, чөлөөт зах зээлд шилжсэн тэр үеэс эхлэн эрс буурсан байна.

1950-аас 1960-аад оны төрөлтийн өсөлтөд тус улсад эрүүлийг хамгаалах салбар хөгжиж, эмнэлэг үйлчилгээний хүртээмж сайжирсан, анагаах ухааны ололт нэвтэрч, нас баралт буурсан, хүн амын ахуй амьдрал, боловсролын түвшин нэмэгдсэн зэрэг нь эерэгээр нөлөөлж байсан бол 1980-аад он гэхэд эдгээр хүчин зүйлсийн зарим нь буюу тухайлбал улам бүр өсөн нэмэгдэх материаллаг баялаг, боловсролын хэрэгцээ нь сөргөөр нөлөөлөх болсон байна. Харин 1990-ээд оны төрөлтийн бууралтад үр хөндөлтийг чөлөөлсөн явдал зах зээлд шилжих үеийн эдийн засгийн бэрхшээлүүдтэй хавсран нөлөөлжээ.

Монголын хүн амын төрөлтийн өсөлт бууралтад тус улсын гадаад дотоод улс төрийн байдал, хүн амын талаар баримталж байсан бодлого эдийн засаг, нийгмийн өөрчлөлт, хотжилт, хүн амын боловсрол, сэтгэхүйн өөрчлөлт зохих ёсоор нөлөөлж байсан юм. Харин төрөлтийг шууд тодорхойлогч хүчин зүйлс нь болох хүүхэд хөхүүлэлт, төрөлт зохицуулалт, гэрлэх ба цэвэрших нас, хурцлын давтамж зэрэг нь төрөлтөд хэрхэн нөлөөлж байсныг 90-ээд он хүртэл тодорхойлох боломж хязгаарлагдмал байгаа юм.

Монголын хүн амын төрөлтийн хандлагыг шинжлэхүйд гэр бүл төлөвлөлтийг хэрэгжүүлж байна уу үгүй юу гэдгээс бус хүн ам хэрэгцээгээ мэдэрсэн үеэс л төрөлтөө зохицуулж эхэлдэг юм байна гэсэн дүгнэлтэд хүрч байгаа бөгөөд тэр нь нийгэм эдийн засаг, улс төр, соёл, бие хүний зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгддөг байна.

Ашигласан хэвлэл

1. Баренбойм С, Гурина А. К вопросу об охране материнства и младенчества в Монголии "Хозяйство Монголии" N4.(11) 1928.
2. Бат-очир Л, Отгонжаргал С. XX зууны монгол дахь улс төрийн түүхэн үйл явц. УБ, 1996
3. Гарын авлага, 1 боть, МУУИС, Хүн ам зүйн сургалт судалгааны төв, 1996.
4. Гур Р. Воспроизводство населения МНР в 1955-1956 и 1962-1963 гг. Дисс. Канд. 1964.
5. Монгол улсын хүн ам СТГ. УБ, 1994
6. Хүн ам ба хөгжил. Монгол улсын хүн амын бодлого хөдөлмөрийн яам. УБ, 1995
7. Mongolia: Yesterday and Today. Tientsin Press. Print. 1925.